



# БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Бэлтгэсэн: "Биржийн бус зах зээлийн бүртгэлийн нэгж"



## MONGOLIAN ASSOCIATION OF SECURITIES DEALERS

 (+976) 7014-3339

 reg@otc.mn

 Chingeltei Dist, 1st Khoroo, Peace Ave, Express tower 11-01



## **Зохицуулалтын сэндрокс орчин дахь үнэт цаасны арилжаа амжилттай хийгдлээ.**

Биржийн бус зах зээлд 2023 оны 12 сарын 14-ний өдрийн 23/107 тоот тогтоолоор бүртгэгдсэн “ЛэндМН ББСБ” ХХК-ийн Лэнд бонд-1 өрийн хэрэгслийн 5 тэрбум бүхий 3 транч, 2023 оны 07 сарын 07-ны өдрийн 23/59 тоот тогтоолоор бүртгэгдсэн “Тера Анлимитед” ХХК-ийн Тера бонд-3 өрийн хэрэгслийн 5 тэрбум төгрөг бүхий 2 транч өрийн хэрэгслүүдийн анхдагч зах зээлийн арилжаа амжилттай хийгдсэн тул андеррайтер компани болон үнэт цаас гаргагчийн хүсэлтийн дагуу 2024 оны I-р улиралд блокчэйн арилжааны системд шилжүүлж, 2024 оны 04 сарын 05-ны өдөр хоёрдогч зах зээлийн анхны арилжаанууд амжилттай хийгдээд байна.

## **Барилга, Банк бус санхүүгийн байгууллагын салбарын судалгааг гарган салбарын оролцогч нарт танилцууллаа.**


Биржийн бус зах зээл дээр Барилга, үл хөдлөх хөрөнгө, Банк бус санхүүгийн байгууллагууд хамгийн их буюу нийт үнэт цаас гаргаж байгаа салбарын 63 хувийг эзэлдэг. Тиймээс энэхүү 2 салбарын сүүлийн 5 жилийн дата мэдээнд үндэслэн салбарын ерөнхий тойм судалгааг Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси ХХК-иар хийж гүйцэтгүүлээд судалгааны үр дүнг салбарын нийт оролцогч нарт нээлттэй хэлбэрээр хүргээд байна.

## **Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журамд нэмэлт өөрчлөлт оруулахаар боллоо.**

2023 оны 01 сарын 11-ний өдрөөс эхлэн шинэчлэн батлагдан даган мөрдөгдөж эхэлсэн Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журамд нэмэлт өөрчлөлт оруулахаар төслийг бэлтгэн зохих этгээдүүдээс санал авч, боловсруулалт хийгдэж байна. Уг өөрчлөлтөөр ТОП 100 аж ахуй нэгжтэй холбоотой зохицуулалтууд болон ББЗЗ-н шууд оролцогч байгууллагуудтай уулзсан уулзалтаар тодорхойлсон журамд тусгагдаагүй эсвэл илүү нарийвчилсан зохицуулалт шаардлагатай байсан зүйлсийг тусган өөрчлөн боловсруулсан болно.

## **Биржийн бус зах зээлийн Бүртгэлийн хорооны үйл ажиллагааны журам шинээр боловсрууллаа.**

Биржийн бус зах зээлийн бүртгэлийн хорооны гишүүний шалгуур, шалгаруулах үндэслэл, эрх хэмжээний асуудлыг нарийвчлан зохицуулсан журам батлаагүй ББЗЗ-н үнэт цаасны бүртгэлийн журмаар зохицуулж байсан. Харин бүртгэлийн хорооны хурлын үйл ажиллагааг “Бүртгэлийн хорооны удирдамж”-аар зохицуулж байсан бол бүртгэлийн хорооны гишүүд, хурлын үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтуудыг нэгтгэн “Бүртгэлийн хорооны үйл ажиллагааны журам”-г боловсруулан холбогдох этгээдүүдээс санал аван боловсруулалт хийгдэж байна. Шинээр боловсруулж буй журамд дээрх асуудлуудыг илүү дэлгэрүүлэн нарийвчлан зохицуулалтуудыг оруулсан болно.





## **Биржийн бус зах зээлийн шууд оролцогчидтой ээлжит хурал зохион байгууллаа.**

Биржийн бус зах зээлийн шууд оролцогч байгууллагуудын удирдах ажилтнуудад 05 сарын 29-ний өдөр санхүүгийн зохицуулах хорооны санхүүгийн хүртээмжийн танхимд ээлжит хурал зохион байгууллаа. Уг уулзалтаар ББЗЗ-н ерөнхий тойм мэдээлэл, "ББЗЗ-н Үнэт цаасны бүртгэлийн журам"-д оруулах нэмэлт өөрчлөлт, "Бүртгэлийн хорооны үйл ажиллагааны журам"-ын хэлэлцүүлэг, болон Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси ХХК-иар гүйцэтгүүлсэн Барилга, ББСБ-н салбарт хийсэн судалгааны үр дүнг танилцуулах зэрэг асуудлуудын хүрээнд хэлэлцсэн болно.

## **Биржийн бус зах зээлийн шууд оролцогч болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд шалгалт зохион байгуулахаар шалгалтын удирдамж боловсрууллаа.**

Биржийн бус зах зээл дээр үнэт цаас гаргахад зуучлалын үйлчилгээ үзүүлсэн андеррайтер компаниудад газар дээрх хянан шалгалт хийхээр төлөвлөн шалгалтын удирдамж боловсруулаад байна. Мөн ББЗЗ дээр олон давтамжтай үнэт цаас гаргасан, үүргээ хугацаандаа биелүүлээгүй, андеррайтер компани олон удаа сольсон, нөхцөлтэй бүртгэгдсэн зэрэг шалтгаануудаас хамаарч 15 үнэт цаас гаргагчийг сонгон үйл ажиллагаатай нь танилцан журмаар хүлээсэн үүргүүдийн биелэлтийг шалгахад удирдамж боловсруулаад удирдах зөвлөлөөр батлуулахаар төлөвлөн ажиллаж байна. Уг шалгалтын бүрэлдэхүүнд ББЗЗ-н бүртгэлийн хорооны гишүүд, Холбооны Сахилгын зөвлөлийн гишүүд, бүртгэлийн нэгжийн мэргэжилтнүүд багтаж байгаа болно.

## **Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албанаас ББСБ-уудын зохистой харьцаа үзүүлэлтийг авч ажиллаж байна.**

СЗХ-н "Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам"-ыг хүчингүй болсонтой холбоотойгоор СЗХ-ны 2023.07.05-ны өдрийн 3/2873 тоот албан бичгийн дагуу өрийн хэрэгсэл гаргахаар хүсэлт ирүүлсэн ББСБ-уудыг СЗХ-с тогтоосон зохистой харьцаа үзүүлэлтийг хангаж байгаа эсэх талаар дүгнэлт авч эхэллээ. Тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооны хяналт шалгалт, зохицуулалтын газраас 14 ББСБ дээр уг дүгнэлтийг гаргуулсан байна.

## **Үүргээ биелүүлээгүй ҮЦК-иудад сануулах САНУУЛГА хүргүүлэв.**

Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журмын 2.19.1-т зааснаар Үнэт цаас гаргагчийн ББЗЗ-д бүртгүүлэх хүсэлт, хавсаргах баримт бичиг, төслийн танилцуулгыг мэргэжлийн түвшинд бэлтгэх, үнэт цаас гаргагчийг таньж мэдэх үүргээ биелүүлж ажиллаагүй мөн уг журмын 6.5.4-т зааснаар Компанийн хувьцааны хяналтын багц эзэмшигч, ТУЗ-ийн Дарга болон Гүйцэтгэх удирдлагад орсон өөрчлөлтийн тухай мэдээллийг ирүүлэх үүргээ биелүүлээгүй үнэт цаасны компаниудад бүртгэлийн нэгж, бүртгэлийн хорооны гишүүдийн санлаар ерөнхий нарийн бичгийн дарга дээрх сануулга хүргүүлэв.

## **Эргэн төлөлт бүрэн хийгдсэн өрийн хэрэгслүүдийг бүртгэлээс хаслаа.**

2024 оны II-р улирлын байдлаар хугацаа нь дуусаж, эргэн төлөлтөө хийсэн өрийн хэрэгслүүд эргэн төлөлтийн тайлангаа баталгаажуулан, OTC.MN платформд оруулсан болно. Уг тайлангуудад хяналт хийж, ҮЦТХТ-тэй эргэн төлөлт хугацаандаа бүрэн хийгдсэн эсэхийг тооцоо нийлж, бүртгэлээс хасаж шийдвэрлэлээ. 2024 оны II-р улирлын байдлаар 71,235,000,000 төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн байна. Ингэснээр нийт 563,836,340,400 төгрөгийн эргэн төлөлт амжилттай хийгдлээ.



# МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ:



Бүртгэлийн хорооны 2024 оны 05 сарын 24-ны өдрийн БХ 24/72 тоот тогтоолоор “Эс жи инвестмент энд секьюритис ҮЦК” ХХК шууд оролцогчоор бүртгэгдлээ.

Бүртгэлийн хорооны 2024 оны 06 сарын 18-ны өдрийн БХ 24/82 тоот тогтоолоор “Булган брокер ҮЦК” ХХК шууд оролцогчоор бүртгэгдлээ.



БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНД  
ОРОЛЦОХ ШУУД ОРОЛЦОГЧООР “ЭС ЖИ  
ИНВЕСТМЕНТ ЭНД СЕКЬЮРИТИС ҮЦК” ХХК-Г  
БҮРТГЭЛЭЭ



БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНД  
ОРОЛЦОХ ШУУД ОРОЛЦОГЧООР  
“БУЛГАН БРОКЕР ҮЦК” ХХК-Г БҮРТГЭЛЭЭ





## Биржийн бус зах зээлийн шууд оролцогчид:

2024 оны II-р улирлын байдлаар Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоонд бүртгэлтэй биржийн бус зах зээлийн арилжаанд оролцох эрхтэй бүртгэлтэй шууд оролцогч нийт 30 байна. Үүнээс Андеррайтер 19, Дилер 25, Брокер 29, хөрөнгө оруулалтын сан 1 компани байна. Харин шууд оролцогч нарт бүртгэлтэй шууд бус оролцогч хувь хүн 2719, хуулийн этгээд 290 байна.

№	Шууд оролцогчид	Андеррайтер	Дилер	Брокер	ХОС
1	Өлзий энд ко капитал ҮЦК	✓	✓	✓	✓
2	Инвескор капитал ҮЦК	✓	✓	✓	✓
3	Стандарт инвестмент ҮЦК	✓	✓	✓	✓
4	Эм ай си си ҮЦК	✓	✓	✓	✓
5	Ард секьюритиз ҮЦК	✓	✓	✓	✓
6	Гүүдсек ҮЦК	✓	✓	✓	✓
7	Голомт капитал ҮЦК	✓	✓	✓	✓
8	Мирэ эссет секьюритис Монгол ҮЦК	✓	✓	✓	✓
9	Би Ди СЕК ҮЦК	✓	✓	✓	✓
10	Нэйшнл секьюритис ҮЦК	✓	✓	✓	✓
11	Апекс капитал ҮЦК	✓	✓	✓	✓
12	Тэнгэр капитал ҮЦК	✓	✓	✓	✓
13	Райнос Инвестмент ҮЦК	✓	✓	✓	✓
14	Ти Ди Би Секьюритиз ҮЦК	✓	✓	✓	✓
15	Таван богд капитал ҮЦК	✓	✓	✓	✓
16	Мандал капитал маркетс ҮЦК	✓	✓	✓	✓
17	Новел инвестмент ҮЦК	✓	✓	✓	✓
18	Лайфтайм инвестмент ҮЦК	✓	✓	✓	✓
19	Бумбат алтай ҮЦК		✓		✓
20	Нэт сек ҮЦК		✓		✓
21	Аргай бэст ҮЦК		✓		✓
22	Монсек ХХК		✓		✓
23	Алтан хоромсог ҮЦК		✓		✓
24	Гацуурт трейд ҮЦК		✓		✓
25	Ди эйч капитал ҮЦК		✓		✓
26	Стоклаб секьюритиз ХХК				✓
27	Мазаалай капитал партнерс ХХК				✓
28	Булган брокер ҮЦК ХХК				✓
29	Эс жи инвестмент энд секьюритис ҮЦК				✓
30	Тээвэр хөгжлийн банк ХХК	✓			
31	Голомт банк ХК	✓			
32	Нийслэлийн эрсдэлийн удирдлагын сан хувийн ХОС				✓

# АРИЛЖААНЫ ТОЙМ:




Биржийн бус зах зээл 2024 оны II-р улирлын байдлаар 33 үнэт цаас гаргагчийн, 34 өрийн хэрэгсэл бүртгэгдлээ. Үүнээс төгрөгөөр 536,700,000,000 үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл бүртгэгдэж, 501,159,000,000 төгрөгийг татан төвлөрүүлэхээр зарласнаас 500,659,000,000 төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн байна. Харин доллароор 23.8 сая ам.доллар бүртгэгдсэнээс 8.9 сая ам.долларыг татан төвлөрүүлэхээр зарлаж, 100% амжилттай татан төвлөрүүлсэн байна. Ингэснээр биржийн бус зах зээл 2021 оны 9 сард анхны өрийн хэрэгслээ бүртгэж үйл ажиллагаагаа эхэлснээс хойш төгрөгөөр 3,163,167,625,526 төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл бүртгэгдэж, 2,488,799,435,526 төгрөгийг татан төвлөрүүлэхээр зарласнаас, 2,449,539,776,326 төгрөгийг амжилттай татан төвлөрүүлээд байна. Харин доллароор 94.8 сая ам.долларын үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл бүртгэгдэж, 54.4 сая ам.доллар татан төвлөрүүлэхээр зарласнаас 54.4 сая ам.долларыг амжилттай татан төвлөрүүлээд байна.

		Нийт	2024 оны II улирал
1	Бүртгэгдсэн үнийн дүн	3,163,167,625,526	94,800,000
2	Татан төвлөрүүлэхээр зарласан	2,488,799,435,526	54,365,000
3	Бодит татан төвлөрүүлсэн	2,449,539,776,326	54,365,000



Бүртгэгдсэн үнийн дүн




Татан төвлөрүүлэхээр зарласан



Бодит татан төвлөрүүлсэн

2021/9 - 2024/3

2024 I Улирал




## Арилжааны үнийн дүнд эзлэх хувь

Тайлант хугацаанд анхдагч зах зээлийн арилжаа 65 хувь буюу 500.3 тэрбум төгрөгийн гүйлгээ эзэлж байгаа бол хоёрдогч зах зээлийн арилжаа 35 хувь буюу 266.6 тэрбум төгрөгийн гүйлгээ эзэлсэн байна.



## Бондын зарцуулалт

Тайлант хугацаанд бүртгэгдсэн бондын зарцуулалтыг авч үзвэл 56 хувийг зээлийн багц нэмэгдүүлэхэд, 24 хувийг барилгын төсөл, 18 хувийг эргэлтийн хөрөнгийн санхүүжилт, 3 хувийг тоног төхөөрөмж худалдаж авахад зарцуулагдахаар бүртгэгдсэн байна.





## 2024 оны II-р улиралд бүртгэгдсэн бонд (ам.доллар)

№	Бондын нэр	Салбар	Бүртгэгдсэн өдөр	Нийт бүртгүүлсэн дүн \$	Бодит татан төвлөрүүлсэн дүн \$
1	Gobi bond 2	Худалдаа үйлдвэрлэл	4/23/2024	\$ 16,800,000	\$ 3,250,000
2	Gem Toson Energy Bond 1	Бусад	5/3/2024	\$ 7,000,000	\$ 615,000
<b>Нийт</b>				<b>\$ 23,800,000</b>	<b>\$ 3,865,000</b>

## 2024 оны II-р улиралд бүртгэгдсэн бонд (төгрөг)

№	Бондын нэр	Салбар	Бүртгэгдсэн өдөр	Нийт бүртгүүлсэн дүн ₮	Бодит татан төвлөрүүлсэн дүн ₮
1	Net Bond 15	Банк бус	4/12/2024	500,000,000	500,000,000
2	Platin bond 1	Борлуулалт	4/3/2024	1,500,000,000	1,500,000,000
3	Bers bond 4	Банк бус	4/5/2024	10,000,000,000	10,000,000,000
4	Tsogts zeel bond 1	Банк бус	4/5/2024	1,500,000,000	1,500,000,000
5	Lend bond 2	Банк бус	4/11/2024	20,000,000,000	7,190,000,000
6	Tus bond 1.1	Банк бус	4/11/2024	5,000,000,000	5,000,000,000
7	DEM bond 1	Банк бус	4/12/2024	2,700,000,000	500,000,000
8	Invescore INVD bond 3	Банк бус	4/19/2024	30,000,000,000	17,000,000,000
9	Toki bond 2	Банк бус	4/19/2024	14,000,000,000	14,000,000,000
10	Unet bond 1	Банк бус	4/25/2024	3,000,000,000	2,700,000,000
11	River town bond 1	Үл хөдлөх	4/29/2024	10,000,000,000	4,000,000,000
12	Enkhbagana Bond	Үл хөдлөх	5/1/2024	3,000,000,000	2,500,000,000
13	Gem Toson Energy Bond 1	Бусад	5/3/2024	10,000,000,000	1,000,000,000
14	RAY bond 1	Банк бус	5/6/2024	2,000,000,000	1,800,000,000
15	M bond 1	Банк бус	5/9/2024	2,500,000,000	1,500,000,000
16	Matsuya bond 1	Бусад	5/9/2024	1,200,000,000	800,000,000
17	INSA bond 3	Борлуулалт	5/10/2024	2,800,000,000	2,800,000,000
18	CTM Bond 3	Банк бус	5/13/2024	500,000,000	500,000,000
19	KA bond 2	Борлуулалт	5/13/2024	25,000,000,000	10,000,000,000
20	EAR bond 1	Үл хөдлөх	5/14/2024	4,000,000,000	1,500,000,000
21	Easy pay bond 1	Банк бус	5/24/2024	2,500,000,000	2,500,000,000
22	Net Auto bond 3	Банк бус	5/30/2024	20,000,000,000	10,000,000,000
23	Bayn bond 3	Худалдаа үйлдвэрлэл	6/3/2024	10,000,000,000	800,000,000
24	NVTS Trade bond 3	Борлуулалт	6/3/2024	14,000,000,000	*
25	Khan bond 3	Үл хөдлөх	6/5/2024	1,500,000,000	500,000,000
26	Zeely bond 3	Банк бус	6/5/2024	2,000,000,000	
27	CTS bond 1	Борлуулалт	6/7/2024	2,000,000,000	1,000,000,000
28	Shunxhlai Bond 3	Борлуулалт	6/18/2024	20,000,000,000	*
29	Buren bond 2	Банк бус	6/18/2024	4,000,000,000	1,200,000,000
30	Baylag bond 1	Банк бус	6/24/2024	1,500,000,000	1,000,000,000
31	Buuruljuut Power Plant Bond 2	Уул уурхай	6/24/2024	300,000,000,000	300,000,000,000
32	Magna bond 1	Банк бус	6/25/2024	5,000,000,000	1,300,000,000
33	Omni bond 4	Банк бус	6/26/2024	5,000,000,000	1,200,000,000
<b>Нийт</b>				<b>536,700,000,000</b>	<b>405,790,000,000</b>



## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, САЛБАР

### Салбараар, Нийт 2021/9-2024/3

Харин биржийн бус зах зээлд нийт бүртгэгдсэн бонд (2021Q1-2024Q2) салбараар нь авч үзвэл Банк бус санхүүгийн байгууллагын бонд 41%, Үл хөдлөх 22%, Санхүү 9%, Хөрөнгө оруулалт 3%, Борлуулалт 10%, Уул уурхай 5%, Худалдаа үйлдвэрлэл 6%, Бусад салбар 4% хувийг тус тус бүрдүүлж байна.



### Салбараар, 2024 оны II улирал

Тайлант хугацаанд бүртгэгдсэн өрийн хэрэгслийг салбараар нь ангилбал Банк бус 63%, Борлуулалт 14%, Үл хөдлөх 9%, Худалдаа үйлдвэрлэл 7%, Уул уурхай 2% бусад салбар 5%-ийг эзэлж байна.



### Бондын хүү төлөгдөх давтамж

Хүү төлөх давтамжаар тайлант хугацаанд бүртгэгдсэн бондын 93% улирал тутам, 2% сар бүр, 5% нь хагас жилээр хүү төлөлтөө хийх бондууд бүртгэгдсэн байна.






## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, САЛБАР

### Жигнэсэн дундаж хүү (Хугацаагаар)

Тайлант хугацаанд төгрөгөөр бүртгэгдсэн бондын нийт дундаж дундаж хүү 19.4 хувь байна. Үүнээс 24 сарын хугацаатай бонд 19.7 хувь, 18 сарын хугацаатай бонд 19.3 хувь, 12 сарын хугацаатай бонд 19.3 хувь байна.

*\*Хөрөнгө оруулагчтай харилцан тохиролцон хүүг багаар тооцсон компаниудыг хасч тооцсон болно.*




### Бондын хугацаа

Бондын хугацааны хувьд тайлант хугацаанд 12 сарын хугацаатай бонд 49% хувь, 18 сарын хугацаатай бонд 28%, 24 сарын хугацаатай бонд 14%, 36 сарын хугацаатай бонд 9%-ийг тус тус бүрдүүлээ.



### Эргэн төлөлт

Биржийн бус зах зээл 2021 оны 9 сард анхны өрийн хэрэгслээ бүртгэж үйл ажиллагаагаа эхэлснээс хойш нийт 565,186,340,400 тэрбум төгрөгийн өрийн хэрэгслийн хугацаа дуусаж, амжилттай эргэн төлөлтөө хийсэн ба 2024 оны II-р улирлын байдлаар 71,235,000,000 тэрбум төгрөгийн эргэн төлөлтийг амжилттай хийж гүйцэтгэсэн байна.



## Биржийн бус зах зээлд үнэт цаас бүртгүүлэхээр төслийн танилцуулга бэлтгэж буй андеррайтеруудад өгөх зөвлөгөө



1. Төслийн танилцуулга болон маягт, дүгнэлтэд техникийн шинжтэй алдаа гаргахаас сэргийлж, материал бэлтгэх явцад дотоод хяналтын тогтолцоог бий болгон мөрдүүлж ажиллах;
2. Бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч солигдон болон эрх бүхий этгээдэд өөрчлөлт орсон тохиолдолд Биржийн бус зах зээлийн бүртгэлийн журмын дагуу ББЗЗ-ийн оролцогч нарт мэдээлэх;
3. Финтек зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-ийн материалыг бэлтгэхдээ Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17.1.7-ийн дагуу бэлтгэсэн мэдээллийн аюулгүй байдлын аудитын дүгнэлтийг хамт ирүүлэх;
4. ББСБ-ийн улирал бүр Санхүүгийн зохицуулах хороо руу илгээх тайланг холбогдох журмын дагуу үнэн зөв илгээсэн эсэх дээр хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулсны дараа материалыг өгөх;
5. Санхүүгийн тайланг явуулахдаа заавал тодруулгатай хамт явуулах;
6. Бүртгэлийн журмаар хүлээсэн үүргээ цаг тухай бүрд биелүүлэн ажиллах;

